



**БАГАНУУР  
ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК ОНӨТҮГ  
ДАРГЫН ТУШААЛ**

2016 оны 11 сарын 08 өдөр

Дугаар A/06

Улаанбаатар хот

┌ Журам батлах тухай ┐

Монгол улсын “Үйлдвэрлэл технологийн паркийн эрх зүйн байдлын тухай” хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.3, Паркийн дүрмийн 5 дугаар зүйлийн 5.1.8 дах заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Паркийн “Нэгж элсүүлэх журам”-ыг 1 дүгээр хавсралтаар, “Нэгжийн бүртгэлийн маягт”-ыг 2 дугаар хавсралтаар баталсугай.

2. Энэхүү журам гарсантай уялдан нэгжид газар ашиглуулах “БАТЛАМЖ”, нэгжийн “ГЭРЧИЛГЭЭ” олгох болсоныг дурьдсугай.

3. Нэгжийн үйл ажиллагаанд энэхүү журмыг мөрдүүлж ажиллахыг Нэгжүүдийн үйлчлэл, зах зээлийн судалгаа хариуцсан мэргэжилтэн /Б.Мичид-эрдэнэ/-д үүрэг болгосугай.



ДАРГА

Ц.ДАВААДОРЖ

“Багануур Үйлдвэрлэл, Технологийн Парк” ОНӨААТҮГ  
даргын 2016 оны 11 сарын 08 өдрийн  
А/06 дугаар тушаалын 1 дугаар хавсралт

## НЭГЖ ЭЛСҮҮЛЭХ ЖУРАМ

“БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК”  
ОРОН НУТГИЙН ӨМЧИТ АЖ АХУЙН ТООЦООТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗАР

### НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Энэхүү журмын зорилго нь хүний эрүүл мэнд, байгаль орчинд халгүй, дэвшилтэт техник технологийг нэвтрүүлэн импортыг орлох, экспортын баримжаатай үйлдвэрлэлийг хөгжүүлэх зориулалттай үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй Багануур Үйлдвэрлэл технологийн парк ОНӨТҮГ /цаашид "парк" гэх/-т нэгжээр элсэхээр гаргасан албан тоотыг хүлээн авах, нэгжээр элсүүлэх, нэгжийн эрхийг түдгэлзүүлэх түүнтэй холбогдсон бусад харилцааг зохицуулахад оршино.
- 1.2. Багануур Үйлдвэрлэл технологийн паркийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхлэх иргэн, хуулийн этгээд /цаашид "паркийн нэгж" гэх/ нь Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай 2009 оны хууль, Улсын Их Хурлын 2003 оны 54 дүгээр болон Засгийн газрын 2011 оны 104 дүгээр тогтоол, холбогдох хууль тогтоомж, шийдвэрийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллана.

### ХОЁР. НЭГЖ ЭЛСҮҮЛЭХ ҮЙЛ ЯВЦ

- 2.1. Иргэн, хуулийн этгээд нь Багануур Үйлдвэрлэл, технологийн паркийн захиргаанд элсэх хүсэлтээ албан тоотоор ирүүлнэ. Тус албан тоотод Бүртгэлийн маягт /хавсралт 1/ болон бүрдүүлэх материалыг заавал хавсаргана.
- 2.2. Паркийн удирдлага нь иргэн, хуулийн этгээдийг энэ журмын 2 дугаар зүйлийн 2.1-д үндэслэн Паркийн нэгжээр элсүүлэх тушаал гаргана.
- 2.3. Иргэн, хуулийн этгээдэд паркийн удирдлага нэгжийн Гэрчилгээ олгоно.
- 2.4. Иргэн, хуулийн этгээдэд газар ашиглуулах Батламжийг паркийн удирдлага олгоно.

### ГУРАВ. ПАРКИЙН НЭГЖЭЭР ЭЛСЭХ АЖ АХУЙН НЭГЖИЙН БҮРДҮҮЛЭХ МАТЕРИАЛ

Нэгжээр элсэх иргэн, хуулийн этгээд нь дараах материалыг бүрдүүлнэ. Үүнд:

- 3.1. Иргэн, хуулийн этгээдийн Улсын бүртгэлийн гэрчилгээ /нотариатаар баталгаажуулсан/ хуулбар
- 3.2. Бизнес төлөвлөгөө
- 3.3. Үйлдвэрийн төсөл
- 3.4. Элсэлтийн хураамж төлсөн баримт

### ДӨРӨВ. НЭГЖЭЭР ЭЛСЭХЭД ТАВИГДАХ ШААРДЛАГА

Нэгжээр элсэх хуулийн этгээд нь дараах шаардлагуудыг хангасан байна.

- 4.1. Монгол улсад мөрдөгдөж буй хууль, дүрэм, журмын дагуу хэвийн үйл ажиллагаа явуулж буй иргэн, хуулийн этгээд байх



- 4.2. Иргэн, хуулийн этгээд нь үйл ажиллагаагаа тогтвортой, тасралтгүй явуулах дунд хугацааны Бизнес төлөвлөгөөтэй байх
- 4.3. Иргэн, хуулийн этгээд нь БҮТП-ийн нутаг дэвсгэрт байршиж, үйл ажиллагаа явуулах үйлдвэрийн төсөлтэй байх
- 4.4. Иргэн, хуулийн этгээд нь өөрийн нэвтрүүлсэн, нутагшуулсан технологи эсхүл патент, лиценз эзэмшдэг бол давуу тал болно.
- 4.5. Иргэн, хуулийн этгээд нь Монгол улсын Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай 2009 оны хуулийн 12 дугаар зүйлд заагдсан чиглэлийн үйлдвэр барихыг хориглоно.

### ТАВ. НЭГЖИЙН ХУРААМЖ

Иргэн, хуулийн этгээд нь анх элсэхдээ элсэлтийн хураамжийг нэг удаа төлнө.

- 5.1. Иргэн, хуулийн этгээд нь элсэлтийн хураамж болох 1.000.000 төгрөгийг нэгжээр элсүүлэх шийдвэр гарахаас өмнө ..... тоот ..... банкны дансанд төлсөн байна.
- 5.2. 5.1-д заасан элсэлтийн хураамжийг паркийн болон нэгжийн хэвийн үйл ажиллагааг хангахад зориулна.

### ЗУРГАА. НЭГЖИЙН ХӨНГӨЛӨЛТ

- 6.1. Паркийн нэгж нь Нэгжийн удирдлагтай байгуулах гэрээнд талууд гарын үсэг зурж баталгаажуулсан өдрөөс эхлэн доорх хөнгөлөлтүүдийг эдэлж эхэлнэ.
- 6.2. Паркийн нэгжийн үндсэн хөнгөлөлт

Д/д	Хөнгөлөлтийн төрөл	Хууль эрх зүйн орчин	Заалт
1.	Үл хөдлөх хөрөнгийн албан татвараас	Үл хөдлөх хөрөнгийн албан татварын тухай 2000 оны хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.4	үйлдвэрлэл, технологийн паркийн удирдлага, нэгжийн үйлдвэрлэл, технологийн парк доторхи барилга байгууламж, бусад үл хөдлөх эд хөрөнгө
		УИХ-ын 2003 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн Үйлдвэрлэл, технологийн парк байгуулж, хөгжүүлэх үндсэн чиглэл батлах тухай 54 дүгээр тогтоолын хавсралтын 7.2.2	экспортын бүтээгдэхүүн үйлдвэрлэж байгаа аж ахуйн нэгжийг тодорхой хугацаанд
2.	Газрын төлбөрөөс	Газрын төлбөрийн тухай 1997 оны хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.9	үйлдвэрлэл, технологийн паркийн удирдлага, нэгжийг үйлдвэрлэл технологийн паркийн зориулалтаар эзэмшүүлсэн газрын төлбөрөөс
		УИХ-ын 2003 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн Үйлдвэрлэл, технологийн парк байгуулж, хөгжүүлэх үндсэн	үйлдвэр барих болон технологийн шинэчлэлт хийх хугацаанд аж ахуйн нэгжийг газрын төлбөрөөс чөлөөлөх, бүтээгдэхүүн үйлдвэрлэж эхэлснээс хойш тодорхой

		чиглэл батлах тухай 54 дүгээр тогтоолын хавсралтын 7.2.1	хугацаанд газрын төлбөрийн хөнгөлөлт үзүүлэх
3.	Орлогын албан татвараас	ААН-ийн орлогын албан татварын тухай 2006 оны хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.33	үйлдвэрлэл, технологийн паркийн эрчим хүч үйлдвэрлэх, дамжуулах шугам сүлжээ, цэвэр усан хангамж, бохир усны шугам, цэвэрлэх байгууламж, авто зам, төмөр зам, харилцаа холбооны дэд бүтэц бий болгоход оруулсан хөрөнгө зэрэгт тус тус тодорхой хугацаагаар
4.	ГАТ ба НӨАТ-аас	УИХ-ын 2003 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн Үйлдвэрлэл, технологийн парк байгуулж, хөгжүүлэх үндсэн чиглэл батлах тухай 54 дүгээр тогтоолын хавсралтын 7.2.3	экспортын бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд зориулан импортлож байгаа түүхий эд, материал сэлбэг, тоног төхөөрөмжийг импортын гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх;
5.		Засгийн газрын 2014 оны 191 дүгээр тогтоолын хавсралтын дагуу ГАТ болон НӨАТ-аас тус тус чөлөөлөгдөнө.	Гаалийн албан татвар болон нэмэгдсэн өртгийн албан татвараас 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэлх хугацаанд чөлөөлөгдөх жижиг, дунд үйлдвэрийн үйлдвэрлэлийн зориулалт бүхий тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслийн жагсаалтыг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай. /Энэ тогтоолын хавсралтад ЗГ-ын 2014-8-14-ний 264-р тогтоолоор нэмэлт орсон/

### ДОЛОО. ПАРКИЙН НЭГЖЭЭС ТҮДГЭЛЗҮҮЛЭХ, ХҮЧИНГҮЙ БОЛГОХ

- 7.1. Иргэн, хуулийн этгээд нь Нэгжийн удирдлагатай байгуулах гэрээнд заасан хугацаанд ашиглаж буй газартаа зориулалтын дагуу үйл ажиллагаа явуулж эхлээгүй тохиолдолд нэгжээс түдгэлзүүлэх үндэслэл болно.
- 7.2. Энэхүү журмын 4.5 дахь заалтыг зөрчсөн эсхүл завдсан тохиолдолд нэгжээс түдгэлзүүлэх үндэслэл болно.

### НАЙМ. БУСАД

- 8.1. Иргэн, хуулийн этгээд нь үйлдвэрлэлийн чиглэлээ өөрчлөх, удирдлага солигдох болон бусад тохиолдолд Паркийн удирдлагад мэдэгдэж зөвшилцсөнөөр Бүртгэлийн маягтыг шинэчлэн өөрчлөлт оруулж болно.
- 8.2. Иргэн, хуулийн этгээд нь элсэлтийн хураамжийг заасан хугацаанд төлөх ба нэгжээс түдгэлзэхэд буцаан олгохгүй болно.
- 8.3. Парк нэгж хоорондын үйл ажиллагааны төлбөрийг Нэгжийн удирдлагатай байгуулах гэрээгээр зохицуулна.
- 8.4. Энэхүү журамтай холбоотойгоор байгуулсан гэрээ, дүрэм, журам, чиглэлийн заалт бүрийг 2 тал үйл ажиллагаандаа хууль адил мөрдөж ажиллана.



“Багануур Үйлдвэрлэл, Технологийн Парк” ОНӨААТҮГ  
 даргын 2016 оны 11 сарын 08 өдрийн  
 №06 дугаар тушаалын 2 дугаар хавсралт

ПАРКИЙН НЭГЖИЙН БҮРТГЭЛИЙН МАЯГТ

Дугаар № ...

... оны ... сарын ... өдөр

№	Нэр	Тайлбар
1. Паркийн нэгжийн тухай		
1.1	Байгууллагын нэр	
1.2	Байгууллагын статус	
1.3	Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар	
1.4	Байгууллагын регистрийн дугаар	
1.5	Байгууллагын үүсэн байгуулагдсан он, сар, өдөр	
1.6	Улсын харъяалал	
1.7	Байгууллагын үйл ажиллагааны чиглэл	
1.8	Байгууллагын танилцуулга, бүтэц зохион байгуулалт	
1.9	Байгууллагын жилийн эргэлтийн хөрөнгийн хэмжээ /тойм/ Байгууллагын үндсэн хөрөнгийн хэмжээ /тойм/	
1.10	Паркийн зорилгод нийцэх эсэх	
1.11	ТЭЗҮ-ийн товч танилцуулга	
1.12	Үйлдвэрийн төслийн зорилго, бүтээгдэхүүн үйлчилгээний товч танилцуулга	
1.13	Байгууллагын байнгын хаяг	
1.14	Утас- суурин, үүрэн	
1.15	И-мэйл хаяг	
1.16	Факс	
2. Нэгжийн удирдлагын тухай		
2.1	Байгууллагын удирдлагын овог, нэр	
2.2	Регистрийн дугаар	
2.3	Харъяалал	
2.4	Гэрийн хаяг	
2.5	Утас – суурин, үүрэн	
2.6	И-мэйл хаяг	
2.7	Иргэний үнэмлэхний хуулбар	

Бүтгэлийн маягт бөглөсөн:

Бүргэсэн:

..... байгууллагын  
 ..... албан тушаалтан  
 ..... овогтой .....  
 Тамга

“Багануур Үйлдвэрлэл, Технологийн Парк”  
 ОНӨТҮГ-ыг төлөөлж  
 ..... овогтой .....

/гарын үсэг/

/гарын үсэг/